Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 200,906.8 мянга, эцсийн үлдэгдэл 588,283.4 мянган төгрөг болж 387,376.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	200,906.8	588,283.4	387,376.6	100.0
<b>Дүн</b>	<b>200,906.8</b>	<b>588,283.4</b>	<b>387,376.6</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 588,283.4 төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн 111,245.5 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 28,618.3 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 55,507.3 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 392,912.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 140,613.6 мянга, эцсийн үлдэгдэл 308,160.0 мянган төгрөг болж 167,546.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл / мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага		7,127.2	7,127.2
Татаас санхүүжилтийн авлага		101,740.0	101,740.0
Байгууллагаас авах авлага	15,066.4	5,300.0	(9,766.4)
Хувь хүмүүсээс авах авлага	5,003.0	4,180.2	(822.8)
Зээлийн авлага	120,544.2	189,812.6	69,268.4
<b>Дүн</b>	<b>140,613.6</b>	<b>308,160.0</b>	<b>167,546.4</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 61.6 хувь буюу 69,268.4 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 33.0 хувь буюу 101,740.0 мянган төгрөг нь эрүүл мэндийн төвийн ЭМД-ын сангаас авах Ковид-19 өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт дутуу авсан холбоотой байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засаг даргын Тамгын газар	1,000.00	8127.2	7,127.2	2.6
ЭМТ		101740.0	101,740.0	33.0
ЕБС	9,950.00	4300.0	-5,650.0	1.40
Цэцэрлэг	1,520.00		-1,520.0	0.00
СХС	120,544.2	189,812.6	69,268.4	61.6
ОНХС	7,599.40	4,180.20	-3,419.2	1.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>140,613.6</b>	<b>308,160.0</b>	<b>167,546.4</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 120,544.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант мянган төгрөгийг барагдуулж оны эцэст 189,812.6- мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна. эрүүл мэндийн төвийн ЭМД-ын сангаас авах Ковид-19 өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт дутуу авсан холбоотой байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 382,652.4 мянга, эцсийн үлдэгдэл 463,301.7 төгрөг болж, 80,649.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	224,833.4	257,228.4	32,395.0
Эм боох материал	18,975.1	31,390.4	12,415.3
Бичиг хэргийн материал	5,366.3	6,664.8	1,298.5
Аж ахуйн материал	24,850.7	46,454.6	21,603.9
Сэлбэг хэрэгсэл	1,093.0	1,093.0	0.0
Түлш, шатах тослох материал	1,550.0	4,231.3	2,681.3
Барилгын засварын материал	5,151.5	7,692.7	2,541.2
Хүнсний материал	255.3	1,165.8	910.5
Бусад хангамжийн материал	91,277.1	106,430.7	15,153.6
Мал амьтад	9,300.0	950.0	-8,350.0
<b>Дүн</b>	<b>382,652.4</b>	<b>463,301.7</b>	<b>80,649.3</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 463,301.7 мянган төгрөг болж өмнөх оноос 80,649.3 мянган төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ 28,292.8 мянга, Эрүүл мэндийн төв 14,343.5

мянга, хүүхдийн цэцэрлэг 10,335.6 мянга, Ерөнхий боловсролын сургууль 27,319.8 мянга, Соёлын төв 913.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	3,573.7	3,018.1	-555.6	0.7
ЗДТГ	81,657.7	109,950.5	28,292.8	23.7
Соёл	25,535.5	26,448.8	913.3	5.7
ЭМТ	42,469.3	56,812.8	14,343.5	12.3
ЕБС	149,300.2	176,620.0	27,319.8	38.1
Цэцэрлэг	80,115.9	90,451.5	10,335.6	19.5
<b>НИЙТ ДҮН</b>	<b>382,652.3</b>	<b>463,301.7</b>	<b>80,649.4</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 573,495.0 мянган төгрөгийн бараа материалын 387,822.71 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 9,505.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 55,890.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж авсан, 120,277.2 мянган төгрөгийг бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Тайлант онд Эрүүл мэндийн төв 46,584.5 мянга, ЕБС 6,457.0 мянга, хүүхдийн цэцэрлэг 5,807.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

Нэмэгдсэн	573,495.0	Хасагдсан	492,845.6
Худалдан авсан	387,822.7	Худалдсан, зарцуулсан	328,353.3
Хандиваар	9,505.0	шилжүүлсэн	136,678.5
Шилжүүлсэн авсан	55,890.1		-
бусад	120,277.2	бусад	27,813.8

*Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,349,434.2 мянга, эцсийн үлдэгдэл 10,511,807.2 мянган төгрөг болж 2,162,373.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	8,200,898.4	10,366,583.2	2,165,684.8	98.6
Барилга байгууламж, орон сууц	6,804,819.0	8,888,992.30	2,084,173.3	84.6
Тээврийн хэрэгсэл	283,305.9	248,239.30	-35,066.6	2.4
Машин тоног төхөөрөмж	580,524.6	678,113.00	97,588.4	6.5
Тавилга эд хогшил	486,519.4	504,759.10	18,239.7	4.8
Түүх соёлын дурсалт зүйл	0.0	0.00	0.0	0.0
Дуусаагүй үйлдвэр	7,400.0	7,400.0	0.0	0.1
Номын фонд	11,364.3	12,114.30	750.0	0.1
Бусад үндсэн хөрөнгө	26,965.2	26,965.20	0.0	0.3
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	148,535.8	145,224.0	-3,311.8	1.4
Программ хангамж	2,334.0	2,334.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	146,201.8	142,890.0	-3,311.8	1.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8,349,434.2</b>	<b>10,511,807.2</b>	<b>2,162,373.0</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 2,162,373.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 84.6 хувь буюу 2,084,173.3 мянган төгрөгийг хөрөнгийн хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна Үүнд ЗДТГ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр

134,092.5 мянга, аймгийн ХХААГ-аас 2,381.5 мянга, ЕБС нь өмнөх оны авлагыг барагдуулан 9,950.0 мянга, УТХО-аар баригдсан сургуулийн барилгыг 1,994,558.4 мянга, дээд шатны төсөв захирагчаас шилжиж ирсэн 34,762.8 тоног төхөөрөмж үндсэн хөрөнгөнд бүртгэсэн, Соёлын төв нь Уул уурхайн байгууллагаас 5,000.0 мянган төгрөгийн морин хуур хөгжим үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, Эрүүл мэндийн төв нь аймгийн ОНӨГ-аас 2,708.5 мянган төгрөгийн вакум хаалт, УИХ-ын гишүүн Адъяасүрэнгээс 12,203.4 мянган төгрөгийн мобайл технологи, ЭМГ-аас 14,359.1 мянган төгрөгийн компьютер, хүчил төрөгч өтгөрүүлэгч аппарат, ургийн зүрхний хэм хэмжигч, вакцины хөргүүр, дагалдах хэрэгсэл зэргийн тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	864,106.8	864,106.8	0.0	8.2
ЗДТГ	2,558,534.3	2,619,893.1	61,358.8	24.9
Соёл	360,445.8	372,385.8	11,940.0	3.5
ЭМТ	1,427,253.4	1,461,015.9	33,762.5	13.9
ЕБС	1,836,385.2	3,886,090.5	2,049,705.3	37.0
Цэцэрлэг	1,302,708.7	1,308,315.1	5,606.4	12.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8,349,434.2</b>	<b>10,511,807.2</b>	<b>2,162,373.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 75,496.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 179,008.1 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 50.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад байдлаар 2,034,304.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна. Мөн ЕБС нь УТХО-аар баригдсан сургуулийн барилгыг 1,994,558.4 мянга шилжүүлэн авсан байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	2,288,858.80	Хасагдсан	
Худалдан авсан	75,496.10	Худалдсан	0.00
Хандиваар	179,008.10	Акталсан	121,172.91
Шилжүүлэн авсан	2,034,304.60	Шилжүүлсэн	5,313.00
бусад	50.00	Бусад	

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,820.4 мянга, эцсийн үлдэгдэл 50.0 мянган төгрөг болж 3,770.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Богино Хугацаат Өр Төлбөр Дүн	3,820.4	50.0	-3,770.4	100.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,820.4	50.0	(3,770.4)	100.0
<b>Дүн</b>	<b>3,820.4</b>	<b>50.0</b>	<b>(3,770.4)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 50.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд Соёлын төвийн өглөг байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Соёлын төв		50.0	50.0	100.0
ЭМТ	3,820.4		(3,820.4)	-
<b>ДҮН</b>	<b>3,820.4</b>	<b>50.0</b>	<b>(3,770.4)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,603,221.0 мянга, эцсийн үлдэгдэл 10,026,411.2 мянган төгрөг болж, 2,423,190.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,023,410.4	2,023,410.4	-	20.2
Өмч: - төрийн	2,023,410.4	2,023,410.4	-	20.2
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,601,129.0</b>	<b>6,055,879.2</b>	<b>2,454,750.2</b>	<b>60.4</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,978,681.6	1,947,121.6	(31,560.0)	19.4
<b>Дүн</b>	<b>7,603,221.0</b>	<b>10,026,411.2</b>	<b>2,423,190.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 31,560.0 мянган төгрөгөөр буурсан нь Өлзийт сумын ЭМТ-ын дахин үнэлгээний дүнтэй тээврийн хэрэгсэл актлуулсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн данс 2,454,750.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2,454,750.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.17-ний өдрийн хуралдаанаар 02/09 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 99,100.0 мянга, хүү торгуулийн орлогыг 6,000.0 мянга, нийт 105,100.0 мянган төгрөгөөр анх баталсан байна. Сумын ИТХ-ын 2021.09.27-ний өдрийн хуралдаанаар 04/08 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 205,112.0 мянга, хүү торгуулийн орлогыг 4,500.0 мянга, нийт 243,112.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Татварын орлого</b>	<b>205,112.0</b>	<b>553,834.1</b>	<b>348,722.1</b>	<b>1,391.6</b>
ИОТХ	7,500.0	37,378.5	29,878.5	498.4
Бууны татвар	2,900.0	3,546.5	646.5	122.3
Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	2,075.8	575.8	138.4
Хадгаламжийн хүүгийн орлого	24,000.0	27,950.8	3,950.8	116.5
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого	3,000.0	3,912.0	912.0	130.4
Газрын төлбөр	1,200.0	1,741.3	541.3	145.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0	8,103.0	2,103.0	135.1
Ан агнуур нөөц ашигласны	136,512.0	382,233.6	245,721.6	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	18,000.0	19,000.0	1,000.0	105.6
Малын тоо толгойн албан татвар		61,237.7	61,237.7	
Бусад орлого	4,500.0	6,654.9	2,154.9	
<b>2.Татварын бус орлого</b>	<b>38,000.0</b>	<b>75,062.5</b>	<b>37,062.5</b>	<b>197.5</b>
2.1.Хүү торгуулийн орлого	38,000.0	75,062.5	37,062.5	197.5
<b>Нийт дүн</b>	<b>243,112.0</b>	<b>628,896.5</b>	<b>(385,784.5)</b>	<b>258.7</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 1,391.6 хувь буюу 385,784.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр хүснэгт-13-т тодорхой харуулсан болно. Орон нутгийн орлого давсан нь төлөвлөгдөөгүй байсан шонхор шувууны агнуурын орлого төлөвлөгдөөгүй байсан 245,721.6 орсон мөн Малын хөлийн татварыг хуулийн дагуу 61.2 мянган төгрөг төвлөрсөн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 4,500.0 мянган төгрөгийн орлогоос 5,754.9 мянган төгрөгийн орлого орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 35,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 68,390.0 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 3,023,361.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,777,439.7 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 2,701,943.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 75,496.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ний өдрийн 2/04 дугаар тогтоолоор нийт 2,754,524.0 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	159,022.40	76,674.2	82,348.20
Засаг даргын Тамгын газар	576,731.50	398,678.6	178,052.90
Сургууль	1,682,175.00	1,083,352.1	598,822.90
Цэцэрлэг	489,798.30	312,716.3	177,082.00
Эрүүл мэндийн төв	600,107.20	544,327.7	55,779.50
Соёлын төв	200,241.90	83,390.6	116,851.30
Сум хөгжүүлэх сан		154,700.0	-154,700.00
Орон нутгийн хөгжлийн сан		100,684.5	-100,684.50
<b>Нийт дүн</b>	<b>3,708,076.30</b>	<b>2,754,524.00</b>	<b>953,552.30</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 2/04 дүгээр тогтоолоор анх 2,754,524.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.05-ний өдрийн 03/04 дугаар тогтоолоор 83,140.2 мянга, 2021.09.27 -ны өдрийн 04/08 тоот тогтоолоор 167,159.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 18,038.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж сумын нийт төсөв 3,023,361.2 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,613,207.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 100,684.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 1,083,539.5 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 52,300.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 38,465.1 мянган төгрөгийг эрүүл

мэндийн даатгалын санхүүжилтээс, 135,165.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 9,782.6 мянган төгрөгөөр дутуу, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 14,263.7 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 67,256.9 мянга, орон нутгийн төсөвт 111,245.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт	Орон нутагийн төсөвт
ИТХ	86,341.2	85,806.6	534.6	99.4		434.7
ЗДТГ	588,969.7	494,547.6	94,422.1	84.0		97176.9
Сургууль	1,110,777.7	1,086,516.2	24,261.5	97.8	22,332.3	
Цэцэрлэг	305,322.8	264,134.4	41,188.4	86.5	34,154.3	
Соёлын төв	95,472.6	81,838.7	13,633.9	85.7		13633.9
Хүн эмнэлэг	544,327.7	519,293.70	25,034.0	95.4	10,770.3	
СХСан	154,700.0	135,650.0	19,050.0	87.7		
ОНХСан	137,449.5	109,652.5	27,797.0	79.8		
<b>Нийт дүн</b>	<b>3,023,361.2</b>	<b>2,777,439.7</b>	<b>245,921.5</b>	<b>91.9</b>	<b>67,256.9</b>	<b>111,245.5</b>

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,777,439.7 мянган төгрөг буюу 91.9 хувьтай буюу 245,921.5 мянган төгрөгийг хэмнэлтийг байгууллага тус бүрээр хүснэгт-15-т тодорхой харуулсан байгаа бөгөөд Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 24,261.5 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 27,797.0 мянга, сум хөгжүүлэх сангийн зардлыг 19,050.0 мянга, ЭМТ-ын урсгал зардлыг 25,034.0 мянга, ЗДТГ-ын урсгал зардлыг 94,422.1 мянга, Цэцэрлэгийн урсгал зардлыг 41,188.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 118,256.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,721.9 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 148,194.5 мянга нийт 280,173.1 мянган төгрөгийн орлого төвлөрсөн ба Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 237,986.5 мянга, Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 9,566.3 мянга, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 22,866.5 мянган төгрөгийг зарцуулж 9,753.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
<b>НИЙТ ОРЛОГО</b>	1,000.0	19,060.4	37,037.6	0.0	223,075.1	280,173.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0	5,338.5	37,037.6	0.0	74,880.6	118,256.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	13,721.9				13,721.9
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	0.0				148,194.5	148,194.5
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	1,000.0	13,607.6	9,871.0	0.0	223,074.2	270,419.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000.0	13,607.6	304.7	0.0	223,074.2	237,986.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			9,566.3			9,566.3
<b>Төсөвт төвлөрүүлсэн</b>	31.1	32.3	0.0	0.0	1,609.9	1,673.3

Эх сурвалж: Өлзийт сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 91.252,5 мянган төгрөгөөр тодотгон баталж 63.030,8 мянган төгрөгийг зарцуулж 28.221,7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 67.7 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал, малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 97.5 хувь 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт 2.5 хувийг тус тус зарцуулжээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 70.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 3,023,361.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,777,439.7 мянган төгрөгийг зарцуулж 91.9 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 12 нэр төрлийн орлогоор 243,112.0 төгрөг төвлөрүүлэхээс 628,896.5 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 1,391.6 хувь буюу 385,784.5 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Өлзийт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Өлзийт сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Үүнээс	
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан				Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБСургууль	1	1	1		1	1			
Цэцэрлэг	1	1	1		1	1			
ЗДТГ	1	1	1		1	1			
ИТХурал	1	1		1					
Соёлын төв	1	1		1					
ЭМТ	1	1	1		1	1			
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагууд 4 байгууллага зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 353,026.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,000.0 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,433.5 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 3,127.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 347,465.3 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ИТХ	0	-								
ЗДТГ	5	5,560.7	1	1,000.0	1	3,127.2	2	1,433.5	1	0
ЕБСургууль	0	-								
Хүүхдийн цэцэрлэг	0	-								
Бага цэцэрлэг	0	-								
ЭМТ	0	-								
СХС	0	-								
СТА зөрчлийн дүн	5	5,560.7	1.0	1,000.0	1.0	3,127.2	2.0	1,433.5	2	-
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	1	-							1	-
ЕБСургууль	2	347,465.3							2	347,465.3
Соёлын төв	0	-								
Хүүхдийн цэцэрлэг	0	-								
Бага сургууль	0	-								
Нийцлийн аудитын дүн	3	347,465.3	-	-	-	-	-	-	3	347,465.3
Нийт дүн	8	353,026.0	1	1,000.00	1.0	3,127.2	2	1,433.5	5	347,465.3

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 5,560.7 мянган төгрөгийн 5 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 347,465.3 мянган төгрөгийн 3 зөрчил тус тус илэрсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 153 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Мэдээлээгүй
1	Бүтэн жил	12	12	10	0	2	0
2	Хагас жил	3	3	3	0	0	0
3	Улирал бүр	2	8	8	0	0	0
4	Сар бүр	5	60	60	0	0	0
5	Тухай бүр	6	72	72	0	0	0
<b>Нийт</b>		<b>28</b>	<b>155</b>	<b>153</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>

Эх сурвалж. Өлзийт сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Баянговь сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Өлзийт сумын ЕБС нь тайлант онд тогтмол зардалд 216,879.6 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 43,375.9 мянган төгрөг байна. Тус онд 1,929.1 төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 43,356.6 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Өлзийт сумын ЗДТГ-ын- 2021 оны төсвийг 398,678.6 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 190,291.1 мянган төгрөг нэмж 584,469.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4,500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор

санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 494,547.6 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 16.0 хувийн хэмнэлт гаргасан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 109,755.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 181,202.7 мянган төгрөг нэмж 290,958.2 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 197,441.7 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 32.1 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 4,893.4 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,856.2 мянган төгрөг зарцуулсан байна.
- Албан томилолтын зардлыг 708.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 704.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 0.6 хувийн хэмнэлт гаргасан.
- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 48,837.2 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 1,545.7 мянган төгрөг хасаж 47,291.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 46877.3 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 1,959.9 мянган төгрөг буюу 4.0 хувь хэмнэсэн.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 37,669.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн 110 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	36,669.3	3	36,669.3			100.0
Нийт	3	36,669.3	3	36,669.3			100.0

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Өлзийт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 1,202.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс алдаа зөрчлийг давтан гаргахгүй 1,202.9 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

### 4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Аудитаар татварын албаны мэдээгээр орон нутгийн орлогын дүн орон нутгийн орлогын дансны хуулгаар болон ТТЗ-чийн нэгтгэсэн тайлангаар орлогын дүнгээс 1202,9 мянган төгрөгөөр илүү мэдээлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн “13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын мэдээг орлогын дансны хуулгатай тулган мэдээлж байх

## 2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: ТТЗ-чийн ИТХ-ын хуралдаанаар батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын 2012.12.06-ны А/742 тоот захирамжаар зохицуулалт хийж, ЕБС-ийн төсвийг 11600,0 мянган төгрөгөөр, Цэцэрлэгийн төсвийг 6438,0 мянган төгрөгөөр, нийт 18038,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байхад сумын ИТХ-аар дээр өөрчлөлтийг батлаагүй зарцуулалт гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн “34.1. Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ: 34.2.1 -д дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон гэснийг зөрчиж ИТХ-ын хуралдаанаар батлаагүй байна” заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ТЭЗ-чийн шийдвэрээр төсөвт зохицуулалт хийсэн тухай бүр өөрчлөлтийг сумын МТХ-ын хуралдаанаар батлуулж Сумын Төрийн сан шийдвэрийн дагуу зарцуулалтын эрхийг нээж гүйлгээг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо</b> 2022	<b>Аудитын нэр:</b>	Өлзийт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b> БНА-2021/15/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		Өлзийт сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:					
1	Аудитаар татварын албаны мэдээгээр орон нутгийн орлогын дүн орон нутгийн орлогын дансны хуулгаар болон ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангаар орлогын дүнгээс 1202,8 мянган төгрөгөөр илүү мэдээлэгдсэн байна.	1,202.9	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	
2	ТТЗ-ийн ИТХ-ын хуралдаанаар батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын 2012.12.06-ны А/742 тоот захирамжаар зохицуулалт хийж, ЕБС-ийн төсвийг 11600,0 мянган төгрөгөөр, Цэцэрлэгийн төсвийг 6438,0 мянган төгрөгөөр, нийт 18038,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байхад сумын ИТХ-аар дээр өөрчлөлтийг батлаагүй байна.	0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	
<b>дүн</b>		<b>1,202.9</b>			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

**6. Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт /мянган төгрөгөөр/**

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
<b>Засаг даргын Тамгын газар</b>		<b>5,560.7</b>			
1	Баянлиг сумын ЗДТГ-т 2016 онд хог тээврийн машинтай холбоотой 1000.0 мянган төгрөгийн авлага үүссэн тус авлагыг нягтлан бодогчийн программд ажиллагсадтай холбоотой авлагаар, Сангийн яамны Э-тайланд байгууллагаас авах авлагаар бүртгэсэн байна.	1,000.0	Санхүүгийн тайланд залруулсан	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Зоригт Б.Батдорж
2	Тус байгууллагын уурын зуухыг түрээслэгч Залаа цагаан хоршоо ХХК нь 7,127.2 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төлөөгүй авлагаар бүртгэсэн ба 2022 оны 02 сард 4,000.0 мянган төгрөгийг төлсөн ба 3,127.2 мянган төгрөгийг төлөөгүй байна.	3,127.2	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Зоригт Б.Батдорж
3	Авлагын дансанд үлдэгдэлтэй байгаа 1000.0 мянган төгрөгийн авлага нь 2016 онд үүссэн олон жилийн насжилттай байгууллагаас авах авлага байна.	1,000.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Зоригт Б.Батдорж
4	Баянхонгор аймгийн Статистикийн хэлтээс нэмэлт дансаар хүлээн авсан хагас жилийн мал тооллогын 12 тоологчийн 433.5 мянган төгрөгийн цалинг Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлээгүй байна.	433.5	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Зоригт Б.Батдорж
5	Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 48,837.2 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 1,545.7 мянган төгрөг хасаж 47,291.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 46877.3 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 1,959.9 мянган төгрөг буюу 4.0 хувь хэмнэлт гаргасан байна.	0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Зоригт Б.Батдорж
6	Тайлант хугацаанд оруулбал зохих 788,877.2 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого зарлагын гүйлгээтэй холбоотой 243807.1 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Зоригт Б.Батдорж
<b>Ерөнхий боловсролын сургууль</b>		<b>0</b>			
1	Тайлант онд тогтмол зардалд 216,879.6 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 43,375.9 мянган төгрөг байна. Тус онд 1,929.1 төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 43,356.6 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байна.	0	Нийцлийн аудитын зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ө.Хашбилэг Б.Мөнхтогтох
2	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 304,108.7 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0	Нийцлийн аудитын зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Ц.Буянтогтох Ж.Золжаргал
<b>Нийт дүн</b>		<b>5,560.7</b>			

оОо